

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 01 сарын 28-ны өдөр

Дугаар: БА-030/2025

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Баянгол дүүргийн 20 дугаар хороонд баригдсан дунд төвөгшилтэй ангиллын зорьтой 3 давхар, 72.0 м*18.0 м, 5184м² хүчин чадал бүхий худалдаа, үйлчилгээний зориулалттай барилга байгууламжид Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 14 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1 Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2024/09/30 огноо, 0000084 дугаар, БА32024/0106;

2.2 Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар: ГГ-09/22;

2.3 Захиалагч: Барилгачин групп ХХК оноосон нэр, 9011369085 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5634954 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, сонголонгийн зам 40/2 гудамж, 9990-7815, 7711-1177 холбоо барих утас, info@barilgachin.mn цахим хаяг;

2.4 Барилгын ажлын гүйцэтгэгч: Барилгачин групп ХХК оноосон нэр, 9011369085 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5634954 регистрийн дугаар, БУ11-344/24 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, сонголонгийн зам 40/2 тоот, 9900-5322, 7766-2277 холбоо барих утас, info@barilgachin.mn цахим хаяг;

2.5 Барилга байгууламжийн Туслан гүйцэтгэгч байгууллага: Голомт Илч Холдинг ХХК оноосон нэр, 9011435131 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5765498 регистрийн дугаар, БУ17-682/23 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөлтэй; Хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 3 дугаар хороо, Бага наран 31-10 тоот, 91010500 холбоо барих утас, dalhaa@gmail.com;

Смарт технологи ХХК оноосон нэр, 9011270085 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар 5447577 регистрийн дугаар, БУ11-823/24 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөлтэй;

Барилга байгууламжийг ашиглалтанд
оруулах комисс

Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 17 дугаар хороо, 4-р хороолол, 35-93 тоот, 9898-7997 холбоо барих утас, Sales@smarttech.mn цахим шуудангийн хаяг;

Жанжин өргөө ХХК оноосон нэр, 9011183120 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар 5287987 регистрийн дугаар, БУ11-16212/22 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар,

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2 дугаар хороо, 5-р хороолол, 2-08 тоот, 1131-5841, 9908-1247 холбоо барих утас, batdelger@esb.mn цахим шуудангийн хаяг;

Дельта Элеватор ХХК оноосон нэр, 9011774066 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6385362 регистрийн дугаар, ӨБ11-305/20 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар,

Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 6 дугаар хороо, 10 -р хороолол 65-121 тоот, 9500-2222, 9997-3838 холбоо барих утас, batamgalan.g@lift.mn цахим шуудангийн хаяг;

Мөнхийн Гэгээ Цонх ХХК оноосон нэр, 9011621026 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар 6085881 регистрийн дугаар, БУ17-085/23 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар,

Хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 5 дугаар хороо, баянгол 60-15 тоот, 9609-1232, 8609-2690 холбоо барих утас, munkhiingegee@gmail.com цахим шуудангийн хаяг;

Монсар ХХК оноосон нэр, 9011307074 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2070189 регистрийн дугаар, БУ19-266/23 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар,

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 1 дүгээр хороо, 34 тоот, 1132-3348, 9911-5056 холбоо барих утас, batulzii7@gmail.com цахим шуудангийн хаяг;

2.6 Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Гаргал ХХК оноосон нэр, 9011507007 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, ЗТ11-725/23 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар;

Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 10 дугаар хороо, зүүн наран 14/57 тоот, 9906-0149 холбоо барих утас;

2.7 Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Барилгачин групп ХХК оноосон нэр, 9011369085 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5634954 регистрийн дугаар,

Хаяг: Улаанбаатар хот Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, сонсголонгийн зам 40/2 тоот, 9990-7815, 7711-1177 холбоо барих утас, info@barilgachin.mn цахим хаяг;

2.8 Барилга байгууламжийн төлөв байдал: Шаардлага хангасан;

Гурав. Дүгнэлтийн хэсэг

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

ХЯНАЛТ

Барилга байгуу
оруу

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

ШАЛГАЛТЫН
ТАЗАР

- Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

Барилга байгууламжийг ашиг
лалтад оруулах комисс

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул
- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1 Дунд төвөгшилтэй ангиллын зорьтой 3 давхар 72.0 м*18.0 м, 5184м² хүчин чадал бүхий худалдаа, үйлчилгээний зориулалттай барилга байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2 Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад 14 хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

3.3 Ашиглагч байгууллагад:

а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4 Комиссын акт хуудас, хуралдааны тэмдэглэл хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох..... хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1 Дунд төвөгшилтэй ангиллын зорьтой 3 давхар, 72.0 м*18.0 м, 5184м² хүчин чадал бүхий худалдаа, үйлчилгээний зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Илтанд

Баянгол дүүргийн 20 дугаар хороо, Барилгачин групп ХХК-ийн захиалгатай Худалдаа, үйлчилгээний цогцолбор (Б блок)

Комиссын дарга:

Хяналт шалгалтын газрын

Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч



(А.Мөнгөн)

Комиссын нарийн бичгийн дарга:

Барилгачин групп ХХК-ийн Дэд захирал



(Б.Наранмандах)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.




БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 20 ДУГААР ХОРОО, БАРИЛГАЧИН ГРУПП ХХК-ИЙН
ЗАХИАЛГАТАЙ, ЗООРЬТОЙ 3 ДАВХАР, 1 БЛОК ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ
КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

Баянгол дүүргийн 20 дугаар хороо, Барилгачин групп ХХК-ийн захиалгатай зоорьтой 3 давхар, 72.0 м*18.0 м, 5184м², (Б блок) худалдаа, үйлчилгээний зориулалттай 1 блок барилгыг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгын 1 дүгээр давхарын зааланд 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр 14 гишүүний бүрэлдэхүүнтэй 13:00 цагт эхэлж, 15:46 цагт дуусав.



Хуралд:

- 1 Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батчимэг
- 2 Комиссын нарийн бичгийн дарга: Гүйцэтгэгч Барилгачин групп ХХК-ийн Дэд захирал Б.Наранмандах
- 3 Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч Г.Батбаатар
- 4 Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч Э.Цогзолмаа
- 5 Барилга хөгжлийн төвийн Барилга барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Д.Батням
- 6 Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн Баруун түгээх төвийн ахлах инженер Э.Ундрахцогт
- 7 Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-ийн мэргэжилтэн М.Жаргалан
- 8 Ус сувгийн удирдах газрын Хэрэглэгчид үйлчлэх албаны менежер Г.Үүрийнгэгээ
- 9 Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх хэлтсийн Барилгын зураг төслийн хяналтын байцаагч, ахмад Б.Дөл-Эрдэнэ
- 10 Үндэсний төв архивын Зураг төслийн баримтын архивын ахлах архивч Э.Шижиртуяа
- 11 Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК Техник хяналтын хэсгийн ахлах байцаагч Б.Дашдорж
- 12 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбооны хүртээмжийн үнэлгээний ажилтан Б.Даваасүрэн
- 13 Зураг төсөл зохиогч Гаргал ХХК захирал Б.Нарантөгс
- 14 Захиалагч тал Барилгачин групп ХХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Батсүх

Барилга

ИРЦИЙН БАЙДАЛ

- Мэдэгдэл хүлээн авсан – 14
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 14

ХЭЛЭЛЦСЭН НЬ :

Баянгол дүүргийн 20 дугаар хороо, Барилгачин групп ХХК-ийн захиалгатай зорьтой 3 давхар, 72.0 м*18.0 м, 5184м², (Б блок) худалдаа, үйлчилгээний зориулалттай 1 блок барилгын ажлын гүйцэтгэл ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Гүйцэтгэгч Барилгачин групп ХХК-ийн Дэд захирал **Б.Наранмандах**

- Комиссын гишүүдийн үүрэг даалгаварын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Зохиогч тал Гаргал ХХК-ийн Захирал **Б.Нарантөгс**

- Комиссын гишүүдийн үүрэг даалгаварын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Захиалагч тал: Барилгачин групп ХХК-ийн Захирал **Г.Батсүх**

- Комиссын гишүүдийн үүрэг даалгаварын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбооны хүртээмжийн үнэлгээний ажилтан **Б.Даваасүрэн**

- Гадна автомашины зогсоолд ХБИ-ны авто машинд зориулсан зогсоолыг стандартын дагуу төлөвлөн хийх / Босоо тэмдэглэгээтэй /
- Явган хүний замд харааны бэрхшээлтэй иргэдийн хөтөч замыг стандартын дагуу хийх.
- Гадна үүдний налуу замд 2 талдаа инел бариул хийх Бариул өндөр - 70 см, Бариул хооронд- 90см.
- Цахилгаан шатанд зарлан мэдээлэгч буюу давхар зарлагч суурилуулах.
- Давхар бүрд ХБИ өндөр настанд зориулан АЦӨ-г гаргах тоноглолыг зөв байлгах.

Үүрэг даалгаварын биелэлтээр ашиглалтанд авах саналтай байна.

Үндэсний төв архивын Зураг төслийн баримтын архивын ахлах архивч

Э.Шижиртуяа

- Ил далд ажлын актыг бүрэн бүрдүүлэх, Баталгаажуулах
- Барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэлд гүйцэтгэгч байгууллага баталгаа гаргах.

ХЯНАЛТ

лга байгуу
оруу

- Архивд баримт бичиг хүлээлгэн өгөх нийтлэг жагсаалтын дагуу баримт бичгийг бүрэн бүрдүүлэх, баримт бичгийн хуудас дугаарлах, дотоод товёог үйлдэх.
 - Баримт бичиг болон ажлын зургийн эх хувийг архивд хүлээлгэн өгөх.
- Үүрэг даалгаварын биелэлтээр ашиглалтанд авах саналтай байна.

Ус сувгийн удирдах газрын Хэрэглэгчид үйлчлэхн албаны менежер **Г.Үүрийнгэгээ**

- Гүний худгын усны сорьц өгч дүгнэлтийг шалгуулах /MNS 0900:2018 стандартын шаардлага хангасан байх,
 - Нян, Хими-физикийн төрөл өгөх/
 - Нөөцийн савны угаалга, халдваргүйжүүлэлт акт үйлдэж шалгуулах
- Үүрэг даалгаварын биелэлтээр ашиглалтад авах саналтай байна.

Барилга хөгжлийн төвийн Барилга барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн дарга **Д.Батням**

- Нормчлолын сангын төлбөр тооцуулах төлөлт хийх.
 - Барилгын материалын тохирлын гэрчилгээ бүрдүүлэлт хийх мөн орчуулга хийх.
 - Барилгын ажлын зургийг өөрчилсөн бол өөрчлөлтийн зурагт магадлал хийлгэн баталгаажуулах.
 - Ил далд ажлын актыг баталгаажуулах
- Үүрэг даалгаварын биелэлтээр ашиглалтанд авах саналтай байна.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК Техник хяналтын хэсгийн ахлах байцаагч **Б.Дашдорж**

- Гаднаас ирж байгаа их кабель дээр вирк хийх
 - шалан дээр резен хийх
 - Цахилгаан холбогдох дизил генратрын төхөөрөмж шаардлагагүй гэсэн албан тоот ирүүлэх
 - Монсарын тусгай зөвшөөрөл ирүүлэх
 - Ливт болон газардуулга хийсэн акт ирүүлэх
- Үүрэг даалгаварын биелэлтээр ашиглалтанд авах саналтай байна.

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн Баруун түгээх төвийн ахлах инженер **Э.Ундрахцогт:**

- Гадна дулаан өөрчлөлтын зураг батлуулах,
 - Гадна угсралын фото акт нөхөж үзүүлэх
 - Гадна 1.2-р худаг цэвэрлэж худаг доторх шугам будах
 - Үзелийн хянах самбар зэрэг дутууг дуусгах
 - Гадна дулааны үзелийн дотор системийн актыг хөндлөнгийн байгуулгаар хянуулах
- Үүрэг даалгаварын биелэлтээр ашиглалтанд авах саналтай байна.

Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-ийн мэргэжилтэн **М.Жаргалан**

- Гадна холбооны угсралтыг тодорхой болгох / Хийгдсэн гэсэн / Нийслэлийн мэдээллийн санд тусгуулах, Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХ-д Техникийн актаар хүлээлгэж өгөх.

- Техникийн өрөөнд кабель цэгцлэх
 - Давхарын самбарт бирк хийх. Фото зургаар баталгаажуулах
- Үүрэг даалгаварын биелэлтээр ашиглалтанд авах саналтай байна.

Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх хэлтсийн Барилгын зураг төслийн хяналтын байцаагч, ахмад **Б.Дөл-Эрдэнэ**

- Өөрчлөлтын зураг дахин магадлалд оруулж батлуулах.
- Галын гидрант угсралтын өөрчлөлтийн зураг гаргах.
- Өөрчлөлтийн зураг магадлалд орж батлуулаагүй тохиолдолд татгалзах саналтай байна.

Үүрэг даалгаварын биелэлтээр ашиглалтанд авах саналтай байна.

Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч **Э.Цогзолмаа**

- ДХ 1,2 - шугам сүлжээний дулаалгыг бүрэн хийж өнгийн туузаар ороож, цэвэрлэх
- Халаах хэрэгслүүд дээр термостат суурилуулах.
- Б1 давхарын АС-ын системийг бүрэн угсарч дуусгах, решетка хийх.
- Давхар бүрийн АС-ийн дуу чимээ, хэвийн ажиллагааны талаарх баталгаа албан тоот ирүүлэх.
- Гадна шугам угсралтын ил далд акт бүрэн баталгаажуулах.
- Дотор Халаалт , холигч насосны узелийн тоног төхөөрөмжийн угсралтын акт бүрэн баталгаажуулах. Барилгын

Үүрэг даалгаварын биелэлтээр ашиглалтанд авах саналтай байна.

Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч **Г.Батбаатар**

- ЗТЗ тусгай зөвшөөрөл үзүүлэх.
- Барилгад хэрэглэсэн бетоны шинжилгээг үе шат бүрээр үзүүлэх.
- Барилгад хэрэглэсэн арматурны шинжилгээ үзүүлэх.
- Техникийн давхарын зурагт өөрчлөлт оруулах гүйцэтгэлийн зураг гаргаж баталгаажуулж үзүүлэх.
- Дээврийн прапетийг хийж дуусгах.
- Лифтийг магадлалд оруулсан дүгнэлт үзүүлэх.
- Заслын ажлыг бүрэн дуусгах
- 00-д хөгжлын бэрхшээлтэй хүнд зориулсан тоноглол хийх
- Зоорийн давхарт пандус бүрэн хийх
- гадна тохижилтыг зургын дагуу хийх
- Лифтэнд ХБИ зориулсан зарлан мэдээлэл.
- Барилгад хэрэглэсэн материал сертификатад

Үүрэг даалгаварын биелэлтээр ашиглалтанд авах саналтай байна.

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **Б.Батчимэг**

- БТХ-ийн 14.3, 14.6 заалтын дагуу барилгад чанарын баталгаа гаргаж албан бичгээр ирүүлэх

ЛТЫН

ашиглалт
ИСС

- Батлагдсан зураг төслөөс өөрчлөлт хийсэн өөрчлөлтийг дахин магадлах эсэх талаар эрх бүхий байгууллагын тодорхойлолт оруулах
 - Захиалагч, зохиогч нар хяналтын нэгдсэн дүгнэлт шинэчилж ирүүлэх.
- Үүрэг даалгаварын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ :

Баянгол дүүргийн 20 дугаар хороо, Барилгачин групп ХХК-ийн захиалгатай зорьтой 3 давхар, 72.0 м*18.0 м, 5184м2, (Б блок) худалдаа, үйлчилгээний зориулалттай 1 блок барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлт үйлдэх, баталгаажуулах, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.


Танилцсан :

Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч



(Б.Батчимэг)

Тэмдэглэл хөтөлсөн :
Барилгачин групп ХХК-ийн
Дэд захирал



(Б.Наранмандах)